



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/355

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.7, 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 13 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081351

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 07 сарын 19-ны өдрийн
А/... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА


№	Овог нэр	Харъяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Яанг Жэймс Маркус Ян Лүн Young James Marcus Yan Loong	Америкийн Нэгдсэн Улс	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төв Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар	ГЭ0002400	Шүд судлал /Шүдний сүвгийн эмчилгээ судлал/	Эмчлэх	2019.07.29-2019.08.03 /6 хоног/
2.	Лафлер Элизабет Шарма Абдалла	Америкийн Нэгдсэн Улс	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төв	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар	ГЭ0002401	Өрхийн анагаах ухаан судлал	Эмчлэх	2019.07.29-2019.08.03 /6 хоног/

	Lafleur Elizabeth Sharma Abdalla		Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв					
3.	Сээкора Каитлин Мари Seykora Caitlin Marie	Америкийн Нэгдсэн Улс	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төв Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар	ГЭ0002402	Ясны гажиг судлал	Эмчлэх	2019.07.29-2019.08.03 /6 хоног/
4.	Вагедес Эми Элизабет Vagedes Amy Elizabeth	Америкийн Нэгдсэн Улс	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төв Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар	ГЭ0002403	Ясны гажиг судлал	Эмчлэх	2019.07.29-2019.08.03 /6 хоног/
5.	Ли Алберт Жон Сүг Lee Albert Jon Suk	Америкийн Нэгдсэн Улс	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төв Төв аймгийн Сүмбэр	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар	ГЭ0002404	Сэргээн засал судлал	Эмчлэх	2019.07.29-2019.08.03 /6 хоног/

			сумын Эрүүл мэндийн төв					
6.	Макдоналд Кимберли Macdonald Kimberly	Америкийн Нэгдсэн Улс	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Эрүүл мэндийн төв Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв	Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар	ГС0000304	Сувилахуй судлал	Сувилах	2019.07.29-2019.08.03 /6 хоног/
7.	Ван Серена Shao Хон Wang Serena Xiaohong	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Америкийн Нэгдсэн Улсын Орбис Интернэшнл байгууллага	ГЭ0002405	Хүүхдийн нүд судлал	Эмчлэх	2019.09.02-2019.09.06 /5 хоног/
8.	Соларти Томас Карлос Эдуардо Solarte Thomas Carlos Eduardo	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Америкийн Нэгдсэн Улсын Орбис Интернэшнл байгууллага	ГЭ0002406	Хүүхдийн нүд судлал	Эмчлэх	2019.09.30-2019.10.05 /5 хоног/
9.	Амина Мохамед Юсеф Иса Иллиас Amina	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/-ын "Ноордофф гавал тархины сан"	ГЭ0002407	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2019.08.27-2019.08.31 /5 хоног/

	Mohamed Yusef Isa Illias							
10.	Ху Юун Чэн Hu Yung Chen	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/-ын “Ноордофф гавал тархины сан”	ГС0000305	Мэдээгүйжүүл гийн сувилахуй судлал	Сувилах	2019.08.27-2019.08.31 /5 хоног/
11.	Чэн Еэх Ен Cheng Yueh Yen	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/-ын “Ноордофф гавал тархины сан”	ГС0000306	Мэдээгүйжүүл гийн сувилахуй судлал	Сувилах	2019.08.27-2019.08.31 /5 хоног/
12.	Пак Жун Хи Park Junhee	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын Чосун их сургууль	ГЭ0002408	Чих, хамар, хоолой судлал	Эмчлэх	2019.08.15-2019.08.18 /4 хоног/
13.	Сацар Saqier	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	-	ГЭ0002409	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	6 сар

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 07 сарын 19-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харъяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Танигүчи Ёшишигэ Taniguchi Yoshishige	Япон Улс	“Бабуно” ХХК-ийн “Мирай Дентал клиник” шүдний эмнэлэг	Япон Улсын “Дэнтал Саппорт” ХХК	ГЭ0002410	Нүүр амны мэс засал судлал	Эмчлэх	1 жил